

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Моомоо	Дугаар	L160
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Баянцагаан
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Маанийн хийд	Сүм хийдийн дугаар	БХБЯ 068
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 8	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Жаргалантын буюу Маанийн хийд

Асуулт:-Жаргалантын сүм хэд орчим ламтай байсан бэ?

Хариулт:-40 ламтай байсан.

Асуулт:-Хийдийн барилгыг юугаар барьсан байсан юм бэ? Мод уу, чулуу юу?

Хариулт:-Түйпүү, шавар түйпүү.

Асуулт:-37 оны хэлмэгдлээс өмнө хамба лам нь хэн гэдэг хүн байсан юм бол? **Тэргүүн лам** нь, багш нь хэн гэдэг хүн байсан юм бол?

Хариулт:-Чойсүрэн гавж, Чойсүрэн унзад гэж байсан юм.

Асуулт:-Тэр айл уул овоогоо тахидаг байсан юм бэ? Тэр хийдийн лам нар.

Хариулт:-Сүмийн овоог тахидаг байсан.

Асуулт:-Сүмээсээ хэр хол байсан юм бэ?

Хариулт:-Ойрхон.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Хэдийд тахидаг байсан юм бэ?

Хариулт:-Зуны эхэн сар.

Асуулт:-Цагаан идээгээр тахидаг байсан юмуу?

Хариулт:-Цагаан идээгээр

Асуулт:-Наадам хийдэг байсан үү?

Хариулт:-Хийдэг байсан, морь уралдаад, бөх барилддаг байсан.

Асуулт:-Цам, **Майдар** гардаг байсан үү?

Хариулт:-Гардаггүй.

Асуулт:-**Гэсгүй** ламыг нь хэн гэдэг байсан юм бол?

Хариулт:-**Гэсгүйг** нь мэдэхгүй

Асуулт:-Гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол?

Хариулт:-Сэндом сахиус

Асуулт:-Чойрын ном үздэг байсан үү?

Хариулт:-Үздэг байсан

Асуулт:-Зурхайн **дацан** байсан үү?

Хариулт:-Байсан

Асуулт:-Төвд лам байсан үү?

Хариулт:-Байхгүй

Асуулт:-Дандаа монгол лам нар байсан үү?

Хариулт:-Дандаа монгол лам нар байсан.

Асуулт:-Аль үрсгал байсан юм бол, улааных үү, шарынх үү?

Хариулт:-Шарынх

Асуулт:-Анх ямар хүн үүсгэж байгуулсан юм бол?

Хариулт:-Нэрийг нь мэдэхгүй. Сүмийн багш

Асуулт:-Багцаагаар хэдэн оны үед юм бол?

Хариулт:-Мэдэхгүй байна

Асуулт:-Хувьсгалаас өмнө үү?

Хариулт:-Өмнө

Асуулт:-1920 оноос өмнө үү

Хариулт:-Өмнө, их дээр үед.

Асуулт:-Энэ сүм хэдэн онд нураагдсан юм бол?

Хариулт:-30 хэдэн онд.

Асуулт:-бурхан шүтээнийг нь яасан юм бол? Хаагдсаны дараагаар

Хариулт:-Байхгүй болсон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-**Лам нарыг** нь бүгдийг нь бариад явчихсан уу?

Хариулт:-Бариад явчихсан.Хэдхэн лам нар хоцорсон. Чойсүрэн унзад баригдаагүй хоцорсон.

Асуулт:-Хурал ном хурахгүй байсан уу?

Хариулт:-Хурахгүй байсан

Асуулт:-Хийдийн байшин барилгыг нь яасан юм бол?

Хариулт:-Сүм төв рүү аччихсан

Асуулт:-Бурхан шүтээнийг нь яасан юм бол?

Хариулт:-Бурхан шүтээн нь байхгүй, сүүлийн ганц бурхан нь энэ байна.

Асуулт:-Одоо танай гэрт байж байгаа юмуу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Тэр хийдэд өөр алдартай лам нар байсан уу?

Хариулт:-Хамгийн алдартай хүн тэр унзад л байсан даа.

Асуулт:-Чойсүрэн унзад гэж үү?

Хариулт:-Тийм

Асуулт:-Та дуу **хоолойгий** нь сонсож байсан уу? Хурал ном хурахад.

Хариулт:-Сонсож байсан.

Асуулт:-Их сайхан хоолойтой юу?

Хариулт:-Их сайхан том хоолойтой.

Асуулт:-Цам, **Майдар** гарч байсан тухай бидэнд ярьж өгөхгүй юу, хэдэн сард гардаг байсан юм бол?

Хариулт:-Майдар гардаггүй байсан. Цам сүүлдээ гардаггүй болсон.

Асуулт:-Тэр хийдийн байшин барилгыг монголчууд барьсан юмуу?

Хариулт:-Тийм.Ганц цагаан суварга барьж хандивлаж байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Тэр цагаан суварга нь тэр хийдийн аль талд нь байсан юм бол?

Хариулт:-Зүүн хойд талд нь.

Асуулт:-Одоо суурь нь байгаа юу?

Хариулт:-байгаа.

Асуулт:-Та тухайн үед хийдэд хүрж байсан уу? хурал номонд

Хариулт:-Үздэг байсан

Асуулт:-Энгийн хүүхэд байсан юмуу, яг лам дээл хувцас өмсөж лам болоогүй юмуу?

Хариулт:-Болоогүй.

Асуулт:-Таны төрөл садангийн том лам нар байсан уу? тэр хийдэд.

Хариулт:-Байсан.

Асуулт:-Энэтхэг, Төвдийн хийдүүдтэй холбоотой байсан юм болов уу?

Хариулт:-Мэдэхгүй байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Эмэгтэй лам байсан уу?

Хариулт:-Байхгүй байсан.

Асуулт:-Сүмийнхээ овоог тахидаг байсан уу?

Хариулт:-Тийм

Асуулт:-Өөр овоо **тахидаггүй** байсан уу?

Хариулт:-**Тахидаггүй** байсан

Асуулт:-Өөр танд ярих юм байвал яриарай. Энэ сүмийн тухай. Хэлмэгдлийн үеэр баригдаж ирсэн лам нараас эргэж ирсэн хүн байгаа юу?

Хариулт:-Үгүй, байхгүй.

Асуулт:-Бүгд байхгүй болсон уу?

Хариулт:-Бүгд байхгүй болсон.

Асуулт:-Хэд орчим лам баригдсан юм бол?

Хариулт:-Олон лам баригдаагүй, цөөхөн лам баригдсан.

Асуулт:-Дандаа том лам нарыг нь бариад аваад явчихсан уу?

Хариулт:-Манай ахыг бас бариад явсан. Манай ээжийн дүү байсан.

Асуулт:-Тэр хийдийн ямар цол хэргэмтэй лам байсан юм бол?

Хариулт:-Эмч байсан.

Асуулт:-Оточ хүн байсан юмуу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Тэгээд бариад явчихсан юмуу?

Хариулт:-Тэгсэн.

Асуулт:-Тэгээд л байхгүй юу?

Хариулт:-байхгүй.

Асуулт:-Тэр хүний нэрийг мэдэх үү?

Хариулт:-Гомбо

Асуулт:-Гомбо гэж оточ хүн байсан юмуу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Тэр сүм хийд нь хэд орчим малтай байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй юм. Олон л малтай байсан. Олон айлууд мал малладаг байсан. Үхэр, адуу, хонь, ямаа ихтэй байсан. Тэмээ цөөхөнтэй.

Асуулт:-Тэр үед сүмд хятад **худалдаачид** ирдэг байсан уу?

Хариулт:-Явдаг байсан юм гэнэ лээ. Намайг мэдээ орсноос хойш би сайн мэдэхгүй юм.

Асуулт:-Таныг бүр 10 орчим настай байхад явж байсан уу?

Хариулт:-Явахаа байчихсан байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Хийдийн ном шүтээнийг авч үлдсэн хүн байхгүй юу?

Хариулт:-Байхгүй.

Асуулт:-Та л нэг сахиусыг нь авч үлдсэн юмуу?

Хариулт:-Энэ дамжиж дамжиж саяхан л над хүнээс ирсэн.

Асуулт:-Яаж авч үлдсэн юм бол бүрэн бүтэн.

Хариулт:-Хүнд л явж байсан юм билээ.

Асуулт:-Хаданд хийчихсэн байсан юм болов уу?

Хариулт:-Үгүй, айлд байсан юм байна лээ.

Асуулт:-Бүрэн бүтнээрээ олдсон муу?

Хариулт:-Хагас. Жаахан юм.

Асуулт:-Ном судруудыг нь яасан юм бол?

Хариулт:-Ачаад явчихсан.

Асуулт:-Монголчууд ачаад явчихсан уу? машинаар уу?

Хариулт:-Тэмээн хөсгөөр

Асуулт:-Хэдэн оны үед ачсан юм бол?

Хариулт:-20 хэдэн онд байхаа.

Асуулт:-Хэлмэгдүүлэлтээс өмнө байх нь ээ?

Хариулт:-Үгүй. Хэлмэгдэлтийн дараа.

Асуулт:-Бурхан шүтээнийг нь тэмээн хөсгөөр ачиж аваад, лам нарыг нь бариад аваад явчихсан юм байна шүү дээ. Том лам нарыг нь ер нь бариад аваад явчихсан уу? Чойсүрэн гэдэг хүн тэгээд баригдсан уу?

Хариулт:-Баригдаагүй. Нас барсан. Тэр эмч байсан хүн.Гомбо эмч гэдэг хүнийг бариад аваад явсан.

Асуулт:-Үлдсэн лам нар нь тараад хурал хурахаа байсан уу?

Хариулт:-Тарсан.

Асуулт:-Сүмийг нь яасан?

Хариулт:-Сүмийг сумын төв рүү аччихсан.

Асуулт:-Бүрэн бүтэн байхад нь харсан уу?

Хариулт:-Харсан

Асуулт:-Их том уу?

Хариулт:-3 дугантай

Асуулт:-1 нь **гол дуган**, 1 нь **чойрын** дуган, 1 нь эм зурхайн дуган байсан юм болов уу?

Хариулт:-Маанийн дуган, **сахиусны** дуган, жасын дуган. Ингээд 3 дугантай байсан. Хоёр жастай байсан.

Асуулт:-Гадуураа хэрмэн хашаатай байсан уу?

Хариулт:-Үгүй. Хашаагүй.

Асуулт:-Ерөөсөө л 3 дугантай байсан гэсэн үг үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тийм, баахан суваргатай. Лам нарын байшинтай.

Асуулт:-Сүмээ тойроод суваргатай. Аль талдаа тэр байшингууд нь байсан юм бол?

Хариулт:-Урд талдаа байсан. Сүмийн дуган нь хойд талдаа.

Асуулт:-**Тойрсон суваргануудаа** юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Дандаа туйпуу.

Асуулт:-Туйпуугаа яаж хийдэг байсан юм бол?

Хариулт:-Хэвэнд шахаад тэгээд хатаачихсан байдаг.

Асуулт:-Монголчууд хийдэг байсан уу?

Хариулт:-Тийм

Асуулт:-Одоо тэр туйпуунаас нь үлдсэн болов уу туурин дээр нь.

Хариулт:-Байгаа.

Асуулт:-Сүм дээрээ ганжиртай байсан уу?

Хариулт:-Байхгүй.

Асуулт:-Хүрд байсан уу?

Хариулт:-Жижиг **хүрдүүд** байсан, дуган дотроо байсан.

Асуулт:-Модоор хийсэн байсан уу?

Хариулт:-Модон, дандаа жижиг мод

Асуулт:-**Лүйжин** тавьдаг лам нар байсан уу?

Хариулт:-Байсан гэсэн. Би мэдээгүй,

Асуулт:-Таны үед байхгүй болчихсон байсан уу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Тухайн үеийн лам нар ямархуу хувцастай байсан юм бол?

Хариулт:-Та нарын өмсөж байгаа дээл шиг.

Асуулт:-Ямархуу өнгөтэй байсан юм бол?

Хариулт:-Улаан, шар

Асуулт:-Даалимбан дээл үү?

Хариулт:-Даалимба, даавуу

Асуулт:-Тэр сүм татвар төлдөг байсан юм болов уу, орон нутгийнхаа захиргаанд.

Хариулт:-Төлдөг байсан. Сүүлдээ төлдөг болсон.

Асуулт:-Эхлээд төлдөггүй байсан юмуу?

Хариулт:-Эхлээд мэдэхгүй.

Асуулт:-Орон нутгийнхаа захиргаанд төлдөг байсан юмуу, Богдод төлдөг байсан юмуу?

Хариулт:-Жасдаа төлдөг байсан байхаа.

Асуулт:-Тэр сүмд хутагт, хувилгаад том лам нар байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Байгаагүй.

Асуулт:-Лам нар нь болохоор хүрэн шар өнгийн даалимбан даавуун дээлтэй байсан, тэгээд монгол гуталтай.

Гавжийн дамжаа, гэвшийн **дамжаа** барьдаг байсан уу? Чойрын ном үзээд.

Хариулт:-Тийм юм байгаагүй.

Асуулт:-Ямар ч байсан **чойр** үздэг л байсан юм байна, эм зурхай үздэг байсан юм байна тиймээ?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Ном барладаг үйлдвэр байсан уу?

Хариулт:-Байхгүй. Хувиараа барладаг, хувийн бартай.

Асуулт:-Хуучны **Ганжуур, Данжуур** хадгалагдаж байсан уу?

Хариулт:-Ганжуур, **Данжуур** байсан.

Асуулт:-Хэлмэгдэлтийн үед л байхгүй болсон уу?

Хариулт:-Байхгүй болсон.

Асуулт:-Ганжуур, **Данжуурыг** хаана хэвлэсэн ном байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Ямар ч байсан байсан уу?

Хариулт:-Байсан. Ганжуур эргэдэг байсан.

Асуулт:-Өдөр бүр гороолдог юмуу?

Хариулт:-Байж байж л нэг эргэдэг байсан.

Асуулт:-Тэр хугацааг нь сайн мэдэхгүй юу?

Хариулт:-Мэдэхгүй.

Хариулт:-Сүм чинь өөр нэртэй байсан уу? одоо энэ нэрлэгдэж байгаа **нэрнээс** өөр нэртэй байсан уу?

Асуулт:-Байхгүй. Сүм л гэдэг байсан.

Хариулт:-Маанийн сүм.

Асуулт:-Ямархуу ая дангаар мааниа хурдаг байсан юм бол?

Хариулт:-7 хоног бүтэн хурна. Өдөр шөнөгүй. Маань тасрахгүй.

Асуулт:-Хуучны засаг захиргааны хуваариар аль аймгийн аль хошуу вэ? Энэ сүм.

Хариулт:-Мартжээ.

Асуулт:-Хийд дээр **жандагладаг** мал хөрөнгө ихтэй хүмүүс байв уу

Хариулт:-Байгаагүй. Жасынхаа хөрөнгөөр л. Жасын мал хөрөнгөөр ард түмнээ тэжээдэг.

Асуулт:-Та сүмийн нэрийг монгол бичгээр бичээд өгөхгүй юу?

Хариулт:-Чадахгүй.

Асуулт:-Өөр энэ сүм хийдэд онцгой юу байсан бэ? янз бүрийн онцгой юм байсан уу? бусад хийдүүдээс онцгой.

Хариулт:-Нэг бяртай хүн байсан.

Асуулт:-Лам хүн байсан юмуу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Лам хүн байсан.

Асуулт:-Та өөрийнхөө тухай ярьж өгөхгүй юу.

Хариулт:-**Гүйдэрийн** хурал хураад, дараа нь маанийн хурал хураад, **тэгж** яваад сүм хийд тарчихсан.

Асуулт:-7, 8 настай сууж байсан юмуу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Та тэр үед ямархуу дээл хувцастай сууж байсан бэ?

Хариулт:-Лам дээл, хүрэн дээл.

Асуулт:-Хүрэн дээл өмсөөд, орхимж агсаад л, монгол гутал өмсөөд л?

Хариулт:-Тийм.

Асуулт:-90-ээд оноос өмнө та далдуур янз бүрийн ном унших тийм боломж байсан уу? Хүнээс нуугдаж хаагдаад уншдаг байсан уу?

Хариулт:-Уншдаггүй байсан.

Асуулт:-Таны сүмд лам болоод суухад чинь хэр олон хүүхдүүд цуг ном сурч байсан бэ?

Хариулт:-10-аад хүүхэд байсан.

Асуулт:-Ном цээжилдэг байсан уу, та нар.

Хариулт:-Цээжилдэг байсан

Асуулт:-Ямар ямар ном цээжилдэг байсан бэ? Итгэл, **Ганданлхавжаа**

Хариулт:-Мэдэхгүй юм, ямар ном байсан юм

Асуулт:-Ямар ч байсан ном цээжилдэг байсан? Таныг сүмийн багшийн хойд дүр гэж ярьдаг юм, тэр ямар учиртай юм бэ?

Хариулт:-Тийм л юм гэнэ лээ.

Асуулт:-Яагаад тэгсэн юм бол?

Хариулт:-Лам байж, тэр намайг авчирч, тэгээд ламын сүнс гэж.

Асуулт:-Яагаад таныг гэж тодруулсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй.